



СЭЛЭНГЭ АЙМГИЙН  
АЛТАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/84

Алтанбулаг

┌ Мал амьтаны халдварт өвчин гарахаас ┐  
урьдчилан сэргийлэх, сэг зэм устгах, ариутгал  
халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, “Мал амьтны эрүүл мэндийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-6.4, 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.3, 7.5, 7.11, Улсын онцгой комиссын 3 дугаар сарын 23-ны өдрийн 02 тоот, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 01 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Хүн малын гоц халдварт, халдварт, шимэгчлэх өвчин гарах тархахаас урьдчилан сэргийлэх, өвөлжилт хаваржилтын хүндрэл болон өвчний улмаас хорогдсон мал амьтны сэг зэм цуглуулах, устгах бэлчээр бууц хашаа хороо, уст цэг усны эх булгийг цэвэрлэж халдваргүйтгэх, мал амьтны өвчлөлийн байдлыг бүртгэх, мэдээлэх, хяналт тавих ажлыг шуурхай чанартай зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч :

Ү. Янжиндулам

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүдэд :

М. Цэгмид

(Тархвар зүйч)

Э. Зориг

(1 дүгээр багийн Засаг дарга)

Н. Мөнхзул

(2 дугаар багийн Засаг дарга)

Г. Мөнхболд

(3 дугаар багийн Засаг дарга)

Л. Гантөмөр

(Бумбат-Өлгий БНН мал эмнэлгийн малын эмч)

Р. Булгаа

(Бөхлөө - Хангай ХХК мал эмнэлгийн малын эмч)

О. Отгонтөгс

(Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Г. Март

(Байгаль хамгаалагч)

З. Амарсайхан

(Байгаль хамгаалагч)

2. “Мал эмнэлэг эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн аян”-ны хүрээнд дараах ажил арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

2.1. Мал амьтны гоц халдварт, халдварт, паразиттах өвчин гарах, тархах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Мал эмнэлэг эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн аяныг” чанартай зохион байгуулах.

2.2 Харьяалах нутаг дэвсгэрт / өөрийн сум орон нутаг доторх/ отор нүүдэл хийх, дамжин өнгөрөх, чиглэл хугацааг тогтоох, шилжилт хөдөлгөөн хийх явцад болон зүй бусаар хорогдсон мал амьтны сэг зэмийг цуглуулах, устгах, халдваргүйтгэх, булаг шанд, худаг уст цэг, малын халаа хороог ариутгах, халдваргүйжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих.

2.3 Малын хашаа хороог цэвэрлэх, өтөг бууц, хөрсөн авах. механик цэвэрлэгээ хийх ажлыг малчдаар бүрэн хийлгэж дуусгах.

2.4 Дээрх ажлыг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд шаардагдах хүн, хүч, тээврийн хэрэгсэл, шатахуун, халдваргүйтгэлийн бодис болон бусад зардлыг орон нутгийн нөөц сан, хөтөлбөрөөс гаргахыг сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан (Р. Насанжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Ажлын хэсгийн ажлын төлөвлөгөө удирдамж, заавар зөвлөмжийн дагуу мал амьтны сэг зэмийг цуглуулж устгах орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажилд идэвхтэй оролцож ахуйн хог хаягдал үнс нурмыг ил задгай хаяхгүй байхыг малчид мал бүхий иргэдэд үүрэг болгосугай.

4. “Мал эмнэлэг эрүүл ахуй, ариутгал халдваргүйжүүлэлтийн аян”- ны хүрээнд хийж гүйцэтгэсэн ажил арга хэмжээ, үр дүнгийн тайланг гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ү.Янжиндулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н. ОТГОНЦОГТ